



ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2015 оны 9 сарын 09 өдөр

Дугаар А/200

Улаанбаатар хот

Арга зүй, шалгуур үзүүлэлтүүд  
батлах тухай

"Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Газрын тухай" хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.8, мөн зүйлийн 23.2.12 дахь заалт, Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдааны 2015 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх арга зүй"-г 1, "Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийг 2, "Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийг 3, "Шугаман байгууламж байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийг 4, "Байгалийн аялал - рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийг 5, "Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийг 6, "Бэлчээр, хадлангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийг 7, "Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийг 8, "Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээний арга зүй, шалгуур үзүүлэлт"-ийг 9 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү арга зүй, шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тохиромжтой байдлын үнэлгээ хийх, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, олон төрөлт газар ашиглалтыг зориулалтаар нь баталгаажуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Газар зохион байгуулалтын хэлтэс /Ж.Батсайхан/-т даалгасугай.

3. Арга зүйг хэрэгжүүлэх ажилд хяналт тавьж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Газрын дэд дарга /Ж.Даваабаатар/-д даалгасугай.

ДАРГА



А.ХҮРЭЛШАГАЙ

0000515